



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 5 сарын 23 өдөр

Дугаар 125

Улаанбаатар хот

### “Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай зарим үйл ажиллагааны багц дүрэм”-ийн 1 дүгээр хавсралтаар баталсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6.8, 6.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Райнос эссет менежмент монгол ҮЦК” ХХК -ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 658,200,000 /зургаан зуун тавин найман сая хоёр зуун мянга/ төгрөгөөр нэмэгдүүлж, хавсралтад заасны дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Райнос эссет менежмент монгол ҮЦК” ХХК /Бэ Санг Хөг /-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН



**“Райнос эссет менежмент монгол ҮЦК” ХХК-ийн  
хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулах өөрчлөлт**

№	Хувьцаа эзэмшигчийн нэр, /Регистрийн дугаар/	Хувьцааны нэрлэсэн үнэ /₮/	Хувьцааны эхний үлдэгдэл			Өөрчлөлт			Хувьцааны эцсийн үлдэгдэл		
			Тоо ширхэг	Үнийн дүн /₮/	Эзлэх хувь /%/	Хувьцааны нэрлэсэн үнэ /₮/	Хувьцааны тоо	Үнийн дүн /₮/	Тоо ширхэг	Үнийн дүн /₮/	Эзлэх хувь /%/
1	“Райнос эссет менежмент” ХХК	10,000	52,690	526,900,000	100	10,000	65,820	658,200,000	118,510	1,185,100,000	100
	Нийт	10,000	52,690	526,900,000	100	10,000	65,820	658,200,000	118,510	1,185,100,000	100